



МОНГОЛ УЛС  
ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 дугаар  
сарын 14 -ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар  
хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 23 дугаар зүйлийн 23.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5, Коронавируст халдвартын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3, 11.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.6, 43 дугаар зүйлийн 43.2.3, 44 дүгээр зүйлийн 44.1.5, Автотээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 209 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацаанд мөрдөх "Хот хоорондын зорчигч, тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Түр журмын хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд (Л.Халтар), дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг Эрүүл мэндийн сайд (Т.Мөнхсайхан), Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга наарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга (Г.Ариунбуян)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2020 оны "Түр журам батлах тухай" 146, "Түр журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 151 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Шадар сайд

Я.СОДБААТАР



Монгол Улсын Шадар сайдын 2020  
156 дугаар тушаалын хавсралт

## ХОТ ХООРОНДЫН ЗОРЧИГЧ, ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү түр журмын зорилго нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалттай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бүрэн цуцлах хүртэлх хугацаанд хот хооронд зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зорчигч тээврийн тусгай үүргийн үйлчилгээ үзүүлэхэд Монгол Улсын хууль тогтоомж, Олон Улсын Эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД 2005), Улсын Онцгой комисс, мэргэжлийн байгууллагаас гаргасан болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мөрддөг нийтлэг дүрэм, журам, заавар, зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Түр журам нь хот хооронд, орон нутаг хооронд зорчих зорчигч тээврийн үйлчилгээ болон албан ажил, хувийн зорилгоор зорчих иргэдэд хамаарна. Тээврийн хэрэгсэл гэдэгт автотээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, зорчигчийн вагон зэрэг тус тус хамаарна.

1.4. Түр журам нь Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх бөгөөд бүх шатны төрийн байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдөнө.

1.5. Энэхүү түр журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журмаар зохицуулна.

### Хоёр. Зорчигч тээврийг зохион байгуулах

2.1. Түр журмын 1.3-т заасан чиглэлд зорчих шаардлагатай иргэдийг нийтийн, хувийн болон албаны тээврийн хэрэгслээр тус тус зорчуулна.

2.2. Улаанбаатар хотоос гарах чиглэлд зорчих хүсэлттэй иргэн нь нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабаас зөвшөөрөл авч, дүүргүүдэд байрлах шинжилгээ авах цэгт очиж PCR шинжилгээ өгнө. PCR шинжилгээний хариу гарсны дараа зорчих хөдөлгөөнд оролцно.

2.3. Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх цэгүүдээр өдөрт зорчих нийт тээврийн хэрэгслийн зорчигчиоос 5 хувьд нь тооцоолон коронавируст халдварын PCR шинжилгээ авч, тандалт судалгаа хийнэ.

2.4. КОВИД-19 вирусийн халдварт илэрсэн бүс, нутгаас зорчих бол орон нутгийн Онцгой комиссоос зөвшөөрөл авч, PCR шинжилгээ хийлгэж хариу бэлэн болсны дараа зорчих бөгөөд тухайн орон нутагт PCR шинжилгээг хийх төхөөрөмжгүй бол түргэвчилсэн шинжилгээг өгч, хариу авсны үндсэн дээр зорчино. Харин коронавируст халдвартын тохиолдол илрээгүй бүс, нутгаас зорчигчид асуумжийн мэдээллийг үнэн зөв гаргаж өгснөөр зорчиж болох бөгөөд тухайн иргэн биедээ иргэний үнэмлэхээ заавал авч явах үүрэгтэй.

2.5. Түр журмын 2.2, 2.3-т заасан шаардлагыг хангасан иргэн хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний хуваарийн дагуу тасалбар түгээх төв рүү цахимаар холбогдон, төлбөрийг төлж, тасалбарыг захиалж авна. Халдвартын эрсдэлгүй, эрүүл бүс, нутгаас зорчих иргэдэд асуумжийн мэдээллийг үндэслэн тасалбар түгээх төвөөс тасалбар олгож болно.

2.6. Түр журмын 2.2, 2.3-т заасан шаардлага хангаагүй болон КОВИД-19 вирусийн түргэвчилсэн оношлуураар шинжилгээний хариу зэрэг болон сэжигтэй гарсан иргэнийг бусад төв, суурин газар руу зорчуулахгүй.

2.7. КОВИД-19 вирусийн халдвартын нөхцөл байдлыг хянах үүднээс 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 12 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл коронавируст халдвартын PCR шинжилгээний хариутай, хүндэтгэн үзэх шалтгаантай /эрүүл мэнд, албан томилолт, буяны ажил/ иргэд болон зайлшгүй шаардлагатай ачаа тээврийн хэрэгсэл /хүнс, шатахуун, түлшний хангамж, өвс, тэжээл, уул уурхай, эм, эмнэлгийн хэрэгсэл/-ийн жолооч нараас бусад иргэдийн Улаанбаатар хотоос гарах хөдөлгөөнийг түр хугацаанд хязгаарлана.

2.8. Улаанбаатар хотоос орон нутаг руу зорчилоор PCR шинжилгээ өгсөн боловч зорчиж амжаагүй байгаа иргэдэд 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06:00 цагаас 18-ны өдрийн 06:00 цаг хүртэл 4 хоногийн хугацаанд зорчих боломжийг олгож, түр журмын 2.4-т хамруулахгүйгээр тээвэрлэлтийг зохион байгуулна.

2.9. 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх цэгүүдэд 1 тээврийн хэрэгслээс 1 иргэнийг төлөөлүүлж, коронавируст халдвартын PCR шинжилгээ авч тандалт судалгаа хийх, тусгай аппликеишн бүхий програмаар асуумж авч бүртгэлжүүлэх, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна.

2.10. Халдвартын тохиолдол бүртгэгдсэн Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон аймгийн Баян-Өндөр, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг сумдаас зорчих иргэдээс PCR шинжилгээний хариу, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Архангай аймгийн Батцэнгэл, Дорноговь аймгийн Айраг сумдаас зорчих иргэдээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийлгэсэн хариуг үндэслэн шалган нэвтрүүлэх цэгээр халдварт хамгааллын дэглэмийг сахиулан нэвтрүүлэх арга хэмжээг авна.

**Гурав. Зорчигч тээврийн хуваарь, тоо бүртгэл**

3.1. Агаарын хөлөг, зорчигчийн вагон, автобусаар зорчих зорчигчдын халдвар хамгааллын дэглэм, хоорондын зай, тэмдэг тэмдэглэгээ зэрэг шаардлагыг Эрүүл мэндийн яамнаас тогтоосон журам, дэглэмийн дагуу тухайн зорчигч тээврийн хэрэгсэлд байршуулна.

3.2. Нийтийн, хувийн болон албаны тээврийн хэрэгслээр зорчих нийт зорчигчдын тодорхой хувьд шалган нэвтрүүлэх цэгүүдэд коронавируст халдварын PCR шинжилгээ авч тандалт судалгаа хийх тусгай апликеийшн бүхий програмаар асуумж авч бүртгэлжүүлэх, дүн шинжилгээ хийх ажлыг Эрүүл мэндийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Онцгой комисс, холбогдох байгууллагууд хамтран зохион байгуулна.

#### **Дөрөв. Зорчигчид тавигдах шаардлага**

4.1. Нийтийн тээврээр буюу зохион байгуулалттай зорчиж байгаа зорчигч нь амны хаалт, бээлий, спиртэн суурьтай гар халдвартгуйжүүлэгч уусмал, хувийн хэрэгцээний зүйлс, замд хэрэглэх хоол, хүнс, хогийн уутыг бэлтгэнэ.

4.2. Зорчигч нь тээвэрлэлтийн туршид халдвар хамгааллын дэглэмийг баримталж (хооллохоос бусад нөхцөлд амны хаалтыг авахгүй байх, бээлий өмсөх, нэг удаагийн амны хаалтыг 2 цаг тутам солих, бээлийг тайлсан тохиолдолд гарыг халдвартгуйжүүлэх, бусадтай биеэр хүрэлцэхгүй байх, ойролцоо суудлын зорчигчтой болон олноор нэг дор бөөгнөрч ярихгүй байх), мэргэжлийн байгууллага болон жолоочийн тавьсан шаардлагыг биелүүлнэ.

4.3. Зорчигч нь тээврийн хэрэгслээр зорчихдоо тээвэрлэлтийн туршид иргэний үнэмлэх, цахим зорчих тасалбарыг өөрийн биед авч явах бөгөөд зөвхөн заасан суудалд сууна.

4.4. Зорчигч нь тээврийн хэрэгсэл дотор болон цонхоор ил задгай нус, цэр, шүлс хаяхгүй, хог хаягдлыг өөрийн бэлтгэсэн хогийн уутанд хийн битүүмжилж, эцсийн зогсоол дээр ирмэгц хогийн цэгт хаяна.

4.5. Зорчигч нь өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх бөгөөд халдвартын шинж тэмдэг илэрвэл тухайн аймаг, нийслэлийн Онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

4.6 Халдвартын эрсдэлтэй бус нутгаас зорчсон иргэд хүрэх газартаа тусгаарлалтын дэглэмийг баримтлан гэрийн ажиглалтад байна.

#### **Тав. Тээвэрлэгчид тавигдах шаардлага, хүлээх үүрэг**

5.1. Автотээврийн тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага дараах шаардлагыг хангах үүрэгтэй.

- 5.1.1. тээвэрлэгч нь халдварт хамгааллын дэглэм, нөхцөлөөс шалтгаалж, тээвэрлэлтийн үнэ хөлсийг урьдчилан тодорхойлж, зохих зөвшөөрлийг авна;
- 5.1.2. аюулгүй зорчих нөхцөл, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж, стандартын шаардлагад нийцсэн зориулалтын тээврийн хэрэгслээр үйлчилнэ;
- 5.1.3. тээвэрлэлтийн гэрээгээр тогтоосон чиглэл, үйлчилгээний цагийн хуваарийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэнэ. Эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зорчигч тээврийн үйлчилгээний цагийн хуваарьт зохицуулалт хийж болно;
- 5.1.4. тээврийн багийн бүрэлдэхүүнд энэхүү түр журам болон онцгой нөхцөл байдлын үед ажиллах заавар, зөвлөмжийг танилцуулсан байна;
- 5.1.5. тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах үүднээс тээврийн багийн аюулгүй байдал, амны хаалт, бээлий, яаралтай тусlamжийн хайрцаг, гар халдвартгүйжүүлэх бодис, биеийн халуун хэмжигч, цэвэрлэгээний цомог, хогийн уут зэргээр хангана;
- 5.1.6. нийтийн тээврийн автобусны эхний эгнээг чөлөөлж, тусгаарлах хаалт (тунгалаг зузаан уут)-аар зорчигчдоос тусгаарлаж, ээлжийн жолоочийн амрах хэсгийг гаргана;
- 5.1.7. тээврийн хэрэгсэлд хөшигнөөс бусад суудлын бүрээс, гоёлын унжуурга зэрэг халдвартын эрсдэлтэй хэрэгсэл ашиглахгүй, гадаргууг халдвартгүйжүүлэх орчинг бүрдүүлнэ;
- 5.1.8. тээврийн хэрэгсэлд зорчигчийг суулгах суудлын зохицуулалт хийж, тэмдэглэгээ хийсэн байна;
- 5.1.9. зорчигч бөөлжих, биологийн шингэн, цус, цэр, өтгөн ялгадсаар тээврийн хэрэгсэл бохирлогдсон үед цэвэрлэгээний цомгийг хэрэглэх бөгөөд халдвартгүйжүүлэх уусмалыг цацаж, нэг удаагийн сальфетка, ариун цэврийн цаасыг ашиглан цэвэрлэгээг хийж хогны уутанд битүүмжлэн халдварт хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах зааварчилга өгнө;
- 5.1.10. тээвэрлэгч нь зорчигчийг бүрэн буулгасны дараа тээврийн хэрэгсэлд халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар бүрэн гүйцэтгүүлнэ;
- 5.1.11. зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж байсан тээврийн хэрэгсэл эвдэрч, цаашид тээвэрлэлтийг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ тухайн орон нутгийн Онцгой комисстoy хамтран аль ойр байрлах төв суурин газраас хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлдэг

аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг үргэлжлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авна. Эвдэрсэн тээврийн хэрэгслийн оронд үйлчлэх тээвэрлэгч нь энэхүү журмын 5.1 дэх заалтыг мөрдөн ажиллана;

5.1.12. согтууруулах ундаа хэрэглэсэн, халуурсан болон өвчний шинж тэмдэг илэрсэн зорчигчийг тээвэрлэхгүй ба холбогдох эрүүл мэнд, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлнэ;

5.1.13. жолооч нь зөвшөөрөгдөөгүй чиглэлд зорчихгүй, зогсохыг зөвшөөрснөөс бусад газарт зогсож, зорчигчийг буулгахыг хориглоно.

5.2. Төмөр замын тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага дараах шаардлагыг хангах үүрэгтэй.

5.2.1 Төмөр замаар зорчигч тээвэрлэх эрх бүхий байгууллага нь халдварт хамгааллын дэглэм, нөхцөлөөс шалтгаалж, тээвэрлэлтийн үнэ хөлсийг урьдчилан тодорхойлж, зөвшөөрөл авна.

5.2.2 Галт тэрэгний ажилтнууд нь энэхүү түр журмыг болон бусад холбогдох заавар, чиглэл, халдварт хамгааллын талаар зааварчилга авч, шугам замын дагуух өртөөдийн харьяалах онцгой комиссын шуурхай штабын утасны дугаарыг бэлтгэсэн байна.

5.2.3 Тээвэрлэгч байгууллага нь ажилтнуудын аюулгүй байдлыг бүрэн хангах зорилгоор хамгаалах хувцас, хэрэгсэл, амны хаалт, бээлий, яаралтай тусlamжийн хайрцаг, гар халдвартгүйжүүлэх бодис, биеийн халуун хэмжигч, цэвэрлэгээний цомог, хогны уут зэргээр хангана.

5.2.4 Вагоны үйлчлэгч нь галт тэргэнд 2 цаг тутамд халдвартгүйжүүлэх уусмалаар чийгтэй цэвэрлэгээ хийх, ингэхдээ зорчигчдоос зайдарж аюулгүй байдлыг хангаж ажиллана.

5.2.5 Галт тэргэнд хөшигнөөс бусад гудас, бүтээлэг, ор хөнжлийн даавуу зэргийг хориглож, гадаргууг халдвартгүйжүүлэх орчинг бүрдүүлнэ.

5.2.6 Галт тэргэнд ажилтан болон зорчигч хувийн ариун цэврийг хэрхэн сахих, халдвараас сэргийлэх талаарх зөвлөмжийг байрлуулж, мэдээллээр хангасан байна.

5.2.7 Вагоны үйлчлэгчийн ажиллах хэсгийг тусгаарлах ба зорчигч хоорондын зайд 2 метр байхаар суудлын зохицуулалт хийнэ.

5.2.8 Тээвэрлэгч байгууллага нь согтууруулах ундаа хэрэглэсэн, халуурсан болон халдварт өвчний бусад шинж тэмдэг илэрсэн зорчигчийг тээвэрлэхгүй байж болно.

5.2.9 Тээвэрлэгч байгууллага нь зорчигчдыг бүрэн буулгасны дараа тээврийн хэрэгсэлд халдвартгуйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар бүрэн гүйцэтгүүлнэ.

5.2.10 Галт тэргэнд ажил үүрэг гүйцэтгэсэн ажилтнуудыг тандалтын үзлэг шинжилгээнд тогтмол хамруулж байна.

5.2.11 Зорчигч тээвэрлэлтийг рэйлбусаар зохион байгуулж болох бөгөөд холбогдох үйл ажиллагааг энэхүү тур журамд заасны дагуу зохицуулна.

5.3 Тээврийн багийн бүрэлдэхүүн дараах шаардлагыг хангах үүрэгтэй:

5.3.1 Тээвэрлэлт хийхээс өмнө КОВИД-19 вирусийн шинжилгээ авах цэгүүдэд шинжилгээ өгнө. Тухайн иргэн биедээ иргэний үнэмлэхээ зайлшгүй авч явах үүрэгтэй.

5.3.2 хувийн хэрэглээний амны хаалт, бээлий, спиртэн суурьтай гар халдвартгуйжүүлэгч уусмал, хүнс, бусад хувийн хэрэгцээний зүйлс, хогийн уутыг урьдчилан бэлтгэнэ;

5.3.3 өөрийн болон зорчигчийн аюулгүй байдлыг хангаж, халдварт хамгааллын дэглэмийг мөрдөж, зорчигчийн тоог халдварт хамгааллын дэглэмийн дагуу тогтоосон тооноос хэтрүүлэхгүй. Тээвэрлэлтийн туршид тээврийн хэрэгслийн агаар сэлгэлтийг анхаарч, агааржуулалтын төхөөрөмжийг тогтмол ажиллуулна;

5.3.4 зорчих тасалбар аваагүй, тухайн чиглэлд зорчих эрхгүй иргэнийг тээвэрлэх, зөвшөөрөгдөөгүй чиглэлд зорчих, зогсохыг зөвшөөрснөөс бусад газарт зогсож, зорчигчийг буулгах, нэмж зорчигч суулгахыг хориглоно.

5.3.5 мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох чиглэлийн улсын байцаагч, бусад төрийн байгууллага, эрх бүхий байгууллагын албан тушаалтын тавьсан шаардлагыг биелүүлж, халдвартгуйжүүлэлт хийх ажилтны зөвлөмж, зааврыг мөрдөнө;

5.3.6 тээвэрлэлтийн явцад холбогдох заавар, хуваарийн дагуу хооллох, амрах боломжийг бүрдүүлнэ;

5.3.7 тээвэрлэлтийн явцад коронавируст халдвартын шинж тэмдэг бүхий зорчигч илэрвэл тухайн аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт мэдэгдэж, төв суурин газарт нэвтрэхгүй, тандалт, судалгааны багийг иртэл зорчигчдыг тээврийн хэрэгсэлд түр байлгана;

5.3.8 тээвэрлэлтийн явцад иргэдийн хэрэглэсэн амны хаалт, бээлий, ахуйн гаралтай хог хаягдлыг тухайн тээврийн хэрэгслийн жолооч

цуглуулж нийслэл, орон нутгийн тогтоосон цэгт битүүмжлэн хаяна. Ил задгай болон бусад цэгт хаяхыг хатуу хориглоно;

5.3.9 хогийг цуглуулж хаяхдаа хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэж халдварт хамгааллын дэглэмийг сайтар мөрднө.

**Зургаа. Хувийн болон албаны тээврийн хэрэгслээр зорчиход тавигдах шаардлага, хүлээх үүрэг**

6.1. Хувийн болон албаны тээврийн хэрэгслээр зорчих жолооч, зорчигч нь замд гарахаас өмнө тогтсон цэгт КОВИД-19 вирусийн шинжилгээ өгнө. Тухайн иргэн биедээ иргэний үнэмлэх, албан ажлаар зорчих бол албан томилолтыг зайлшгүй авч явах үүрэгтэй.

6.2. Жолооч нь өөрийн болон зорчигчийн аюулгүй байдлыг хангаж, халдварт хамгааллын дэглэмийг мөрдэж, зорчигчдын тоог халдварт хамгааллын дэглэмийн дагуу тогтоосон тоонос хэтрүүлэхгүй.

6.3. Жолооч нь зөвшөөрөгдөөгүй чиглэлд зорчихгүй, зогсохыг зөвшөөрснөөс бусад газарт зогсож, зорчигчийг буулгахгүй.

6.4. Мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох чиглэлийн улсын байцаагч, бусад төрийн байгууллага, эрх бүхий байгууллагын албан тушаалтны тавьсан шаардлагыг биелүүлж, халдвартайжүүлэлт хийх ажилтны зөвлөмж, зааврыг мөрднө.

6.5. Зорчих явцад хэрэглэсэн амны хаалт, бээлий, ахуйн хог хаягдлыг тухайн тээврийн хэрэгслийн жолооч цуглуулж нийслэл, орон нутгийн зөвшөөрөгдсөн хог хаягдлын цэгт битүүмжлэн хаяна. Ил задгай болон бусад цэгт хаяхыг хатуу хориглоно.

6.6. Жолооч нь хогийг цуглуулж хаяхдаа хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэж халдварт хамгааллын дэглэмийг сайтар мөрднө.

6.7. Тухайн орон нутагт зорчигч очмогц 7 хоногийн хугацаанд өөрийгөө гэртээ тусгаарлан, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалж, зохих дэглэмийг мөрдөх бөгөөд халдвартын шинж тэмдэг илэрвэл тухайн аймаг, нийслэлийн Онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Коронавируст халдвартын тохиолдол бүртгэгдээгүй бүсээс ирсэн тээврийн хэрэгслээс төлөөлүүлж 1 зорчигчоос PCR шинжилгээ авсан бол шинжилгээний хариу тодорхой болох хүртэл хугацаанд тусгаарлалтын дэглэмийг дагаж мөрднө.

**Долоо. Аймаг, нийслэлийн Онцгой комиссын үүрэг**

7.1. Аймаг хооронд болон сум хооронд иргэдийг зорчуулах үйл ажиллагааг Аймгийн Онцгой комисс тухай бүр Улсын Онцгой комиссын Шуурхай штабт танилцуулсны үндсэн дээр энэхүү түр журмын дагуу зохион байгуулна.

7.2. Жолооч, тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг тогтоож, жолооч (ээлжийн жолооч)-д халдварт хамгааллын дэглэм (амны хаалт, бээлий)-ийг чанд сахиулна.

7.3. Тусгай үүргийн хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг зохицуулах үеийн коронавируст халдвартай холбоотой батлагдсан журам, зөвлөмжийн хэрэгжилтийг ханггуулж, хяналт тавина.

7.4. Тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт, хог хаягдлын устгалын үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар заавар, журмын дагуу гүйцэтгүүлнэ.

7.5. Дамжин өнгөрч байгаа зорчигч тээврийн хэрэгслийн шатахуун авах, зорчигчийг өөрсдийн бэлтгэсэн хоол, хүнсийг хэрэглэх, бие засах цэгүүдийг тодорхой зааж өгнө.

7.6. Коронавируст халдварын шинж тэмдэг бүхий зорчигч илэрвэл холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан арга хэмжээг даруй авна.

7.7. Тусгаарлах байрыг урьдчилан бэлтгэх ба тухайн орон нутагт ирсэн иргэнд халдварын шинж тэмдэг илэрсэн бол шууд тусгаарлана.

7.8. Тухайн орон нутагт ирсэн болон явсан иргэдийн нэгдсэн тоо, бүртгэлийг гаргаж, Улсын Онцгой комиссын Шуурхай штабт болон холбогдох байгууллага, зэргэлдээ орон нутгийн Онцгой комисст тухай бүр мэдээллийг хүргүүлнэ.

7.9. Цаг агаарын хүндрэлээс шалтгаалан тээвэрлэлт үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн орон нутгийн Онцгой комиссоос зорчигчдыг түр байрлуулах байрны асуудлыг шийдвэрлэж, халдварт хамгааллын дэглэмийг сахиулна.

#### **Найм. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын үүрэг**

8.1. Шалган нэвтрүүлэх цэгээр нэвтэрч буй иргэдийг тусгай аппликеishн бүхий гар утсаар асуумж авах дүн шинжилгээ хийх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

8.2. Халдварын шинж тэмдэг бүхий сэжигтэй зорчигч байгаа талаар мэдээлэл ирсэн тохиолдолд тухайн орон нутгийн Онцгой комиссын шуурхай штабаас мэдэгдсэний дагуу тухайн тээврийн хэрэгслийг төв суурин газарт нэвтрэхээс өмнө Шуурхай хариу арга хэмжээний багийг явуулж, холбогдох арга хэмжээ авна.

8.3. Тээвэрлэгдэн ирж буй иргэдийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн тусламжийг үзүүлнэ.

8.4. Зорчигчдоос сэжигтэй тохиолдол илэрсэн үед тухайн орон нутгийн Онцгой комиссын шуурхай штаб, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 80086829, 100 дугаарын утсанд мэдээлж, холбогдох тушаал, журмын дагуу арга хэмжээг авна.

8.5. Албан хаагчдад халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлах, хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөх, тайлах сургалтыг зохион байгуулж, хяналт тавина.

8.6. Тухайн орон нутагт Зоонозын өвчин судлалын төвгүй бол Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалын 8 дугаар хавсралтад заасны дагуу халдвартын эрсдэлтэй бүс нутгаас ирсэн болон тээвэрлэлтийн явцад сэжигтэй тохиолдол илэрсэн үед тээврийн хэрэгсэлд хийх халдвартгүйжүүлэлтийг Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгээр мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулна.

**Ес. Халдвартгүйжүүлэлт хийх эрх бүхий байгууллагад тавигдах шаардлага, хүлээх үүрэг**

9.1. Халдвартгүйжүүлэлт хийх байгууллага нь ахуйн шавьж, мэрэгч устгах, халдвартгүйжүүлэлт хийх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

9.2. Халдвартын сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн үед голомтын эцсийн халдвартгүйжүүлэлт, хог хаягдлын устгалыг нийслэлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймагт Зоонозын өвчин судлалын төв хариуцан гүйцэтгэнэ. Тухайн орон нутагт Зоонозын өвчин судлалын төвгүй бол түр журмын 8.6-д заасны дагуу зохион байгуулна.

9.3. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалын 8 дугаар хавсралтын дагуу халдвартгүйжүүлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

9.4. Халдвартгүйжүүлэлт хийх ажилтныг халдвартгүйжүүлэлтэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байна.

9.5. Цаг агаарын хүндрэлээс шалтгаалан тээвэрлэлт үргэлжлэх боломжгүй болсон үед зорчигчдыг түр байрлуулсан байранд ариутгал, халдвартгүйжүүлэлтийг хийнэ.

**Арав. Цагдаагийн байгууллагын үүрэг**

10.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын шинжилгээний хариуг шалгаж зорчигчдын аюулгүй байдалд хяналт тавина.

10.2. Зорчигч тээврийн хэрэгсэл харьяа нутаг дэвсгэрээр өнгөрөх хугацаанд чиг үүргийн дагуу хяналт тавьж, зохицуулна.

10.3. Иргэнийг байнга оршин судаг нутаг дэвсгэр рүү зорчиж байгаа эсэхэд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавина.

10.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаарх хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллана.

10.5. Цагдаагийн Ерөнхий газар нь зорчигч тээвэрлэсэн талаарх нэгдсэн мэдээг Улсын Онцгой комиссын Шуурхай штабын [uok.shtab@nema.gov.mn](mailto:uok.shtab@nema.gov.mn)цахим хаяг, 320103 утсаар тухайн өдрийн 10.00, 18.00 цагт тус тус хүргүүлнэ.

#### **Арван нэг. Мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг**

11.1. Зорчигч тээвэрлэлтийн үеийн халдвараас сэргийлэх дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавина.

11.2. Тээврийн хэрэгслийн халдвартгүйжүүлэх бодисын хадгалалт, хамгаалалт, чанар хэрэглээний аюулгүй байдалд хяналт тавина.

11.3. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын зорчигч тээврийн хэрэгсэлд хийж буй халдвартгүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавина.

11.4. Коронавируст халдвараас сэргийлэх мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөөг хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, жолооч, зорчигчид өгнө.

#### **Арванхоёр. Хэрэгжилт, хариуцлага**

12.1. Түр журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, заавар, дүрэм, журам зэрэгт нийцсэн байна.

12.2. Энэхүү түр журмыг дагаж мөрдөөгүй зорчигч, тээвэрлэгчид болон хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

--- ооо ---